

Улсын бүртгэлийн дугаар_00387_
2016 оны _11_ сарын _07_-ны өдөр

**ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ГАЗАР
АШИГЛУУЛАХ ГЭРЭЭ**

2016_оны 12_сарын_28_-ны өдөр

Говь-Алтай аймаг Цээл сум

НЭГ. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Газрын тухай хууль, Говь-Алтай аймаг /нийслэл/-ийн _Цээл_сум /дүүрэг/-ийн Засаг даргын 2016_оны_11_-р сарын_07_-ны өдрийн_A/69_тоот шийдвэрийг үндэслэн газар ашиглуулагчийг төлөөлж Цээл сум /дүүрэг/-ын газрын асуудал эрхэлсэн албан тушаалтан Баасанжав овогтой Насанбуян, газар ашиглагчийг төлөөлж /_____Уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй //иргэн, аж ахуйн нэгжийн нэр/ ажилтай “Алтайн Хүдэр” ХХК –ны Таян нуурын уурхайн Хууль зүйн хэлтсийн дарга Дашравдан Баттүвшин нар энэхүү гэрээг байгуулав.

Энэхүү гэрээний салшгүй хэсэг болох дараахь зүйлийг заавал тусгах бөгөөд эдгээрийн бүрдэл дутуу бол гэрээг хүчингүй тооцох үндэслэл болно. Үүнд:

- 1.1. Газрын байршил, хэмжээ, хил хязгаар, заагийг тодорхой харуулсан кадастрын зураг
- 1.2. Газар ашиглуулагчаас газар ашиглагчид тус газрыг хүлээлгэн өгсөн акт
- 1.3. Газрын төлөв байдал, чанаарын улсын хянан баталгааг Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу хийлгүүлж баталгаажуулсан баримт.

ХОЁР. Гэрээний нөхцөл

2.1. Газар ашиглагчид олгосон газрын нийт хэмжээ_2.0 га_____/га/. Үүнээс:

Нэгж талбарын тодорхой хэсгийг ашиглах
зориулалт

Тухайн зориулалтаар ашиглах
газрын хэмжээ

1. _____ Авто зогсоол, пүү хойд талд _____ /га/
2. _____ Цахилгаан, станц_____ 2.0 га _____ /га/
3. _____ зориулалтаар _____ /га/
4. _____ /га/
5. _____ /га/

2.2. Газрын төлбөрийн хэмжээ

Нэгжийн үнэ 8000 төгрөг /үсгээр Найман мянган төгрөг _____/төгрөг/
Бүгд үнэ 16000 төгрөг /үсгээр Арван зургаан мянга /төгрөг/

Үүнээс

1-р улиралд 4000 төг 3-р улиралд 4000 төг
2-р улиралд 4000 төг 4-р улиралд 4000 төг

2.3. Газрын төлбөрийг улирал бүрийн эхний сарын 25-ны дотор газар эзэмшүүлэгчийн
ХААН банк 100050000943 тоот дансанд шилжүүлж байна.

/Банкны салбарын нэр, дансны дугаар/

2.4 Газар ашиглах тухай эрх бүхий Засаг даргын шийдвэр гарсан өдрөөр газрын төлбөр хийх хугацааг тооцно.

2.5. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр газрын төлбөрийн хэмжээ өөрчлөгдөх тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулна. Ийнхүү газрын төлбөрийг шинэчлэн тогтоолгоогүй бол зохих зардлыг ашиглагч хүлээнэ.

ГУРАВ. Газар ашиглагчийн эрх, үүрэг

- 3.1. Гэрээний нөхцлийн дагуу газрыг эзэмших, ашиглах
- 3.2 Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг газар өмчлөгчөөс гаргуулж авах
- 3.3 Газарт учруулсан хохирлыг гэм буруутай этгээдээр тогтоосон журмын дагуу нөхөн төлүүлэх
- 3.4 Гэрээгээр хүлээсэн үргээ зохих ёсоор биелүүлж ирсэн бол эрхийн гэрчилгээний хугацаа дуусахад уг газрыг үргэлжлүүлэн ашиглахаар гэрчилгээний хугацааг сунгуулах
- 3.5 Газрын төлбөрийг газрын ашигт шинж чанарыг ашигласан эсэхээс үл хамааран хугацаанд нь төлөх
- 3.6 Төлбөрийг хугацаанд нь гүйцэтгээгүй тохиолдолд гүйцэтгээгүй үүргийг үнийн дүнгийн 0,5 хувиар хоног тутам алданги төлөх
- 3.7 Ашиглалтын газрыг бүхэлд нь буюу зарим хэсгийг бусад ашиглуулах бол эрх бүхий Засаг даргаас зөвшөөрөл авч, энэ тухай улсын бүртгэлд бүртгүүлэх
- 3.8 Газар ашиглуулагчаас газрын эзэмшил, ашиглалттай холбгдуулан тавьсан шаардлагыг цаг тухайд нь биелүүлэх
- 3.9 Холбогдох хууль тогтоомжоор тогтоосон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх

ДӨРӨВ. Газар ашиглуулагчийн эрх үүрэг

- 4.1. Газар ашиглагч газрыг гэрээний дагуу ашиглаж байгаа эсэхийг хянах:
- 4.2 Уг газрыг ашиглуулахын зэрэгцээ дараахь шаардлагыг газар ашиглагчид тавих эрхтэй.

Үүнд:

- ✚ Газрын төлөв байдал чанарыг доройтуулахгүй байх, барилгаас 500м-т тохижилт, цэвэрлэгээг хариуцах.
- ✚ Уурхайн өнгө үзэмжид тохирсон төмөр хашаа, хайс ашиглалтын талбайдаа татах.
- ✚ Сумын тохижилт, зохион байгуулалттай холбоотой Орон нутгийн захиргааны шийдвэр, тогтоосон журмыг бүрэн биелүүлэх.
- ✚ Газрын төлбөрөө гэрээнд заасан хугацаанд нь тогтмол бүрэн төлөх.
- ✚ Тухайн газраа 2 жил дараалан гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглаагүй, Дээрх нөхцөлүүдийн аль нэг заалтыг зөрчсөн тохиолдолд газар ашиглах эрх хүчингүй болно. /Захирамж гарсан өдрөөс эхлэн 2 жилийн хугацааг тооцно./

4.3 Газрыг гэрээний нөхцлийн дагуу ашиглаагүй, энэ талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй буюу “Газрын тухай” хуулийн 40.1.1-40.1.6 дугаар зүйлд заасан нөхцөл бий болсон тохиолдолд гэрээг хүчингүй болгож, мөн хуулийн 62 дугаар зүйлд зааснаар хохирлыг нөхөн төлөхийг шаардах

4.4 Газар ашиглах гэрээг жил бүр дүгнэх

4.5 Холбогдох хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх

ТАВ. Газрын талаарх эд хөрөнгийн эрхийн зарим зохицуулалт

- 5.1 Газар ашиглагчийн өмчлөлд байгаа тухайн газар дээрх үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх өөр этгээдэд шилжвэл Энэ тухай Газрын албанд 30-аас доошгүй хоногийн дотор мэдэгдэх гэж шийдвэрлэнэ.
- 5.2. Газар ашиглах эрх болон гэрээний хугацаа дуусгavar болоход тухайн газар дээрх барилга байгууламж, бусад эд хөрөнгийг хэрхэх тухай анх эрх олгосон шийдвэрт заасан бол тэр дагуу,

харин заагаагүй бол Уг газар дээрх барилга байгууламж бусад эд хөрөнгө өмчлөгч этгээдийн тэрхүү эд хөрөнгөө тухайн газар дээр ашиглах эрх дуусгавар болно гэж шийдвэрлэнэ.

5.3. Энэхүү гэрээгээр ашиглалтын газрыг хязгаартай ашиглах эрх бүхий газар ашиглагч байгаа болон ийнхүү ашиглахаар шаардсан бол түүний газар ашиглах нөхцөл, журам нь Монгол Улсын Газрын тухай хуулийн 35.3.5 дахь заалтыг мөрдөж ажиллана тус тус болно. Шаардлагатай гэж үзвэл энэхүү гэрээнд хавсаргаж болно.

5.4. Газар ашиглагчийн газрыг бүхэлд нь буюу зарим хэсгийг гэрээний хугацаа дуусахаас өмнө эрх бүхий байгууллага улсын тусгай хэрэгцээнд нөхөн олговортойгоор солих буюу эргүүлэн авах тухай шийдвэр гаргавал уг шийдвэрийн үндэслэл болсон талуудын урьдчилсан тохиролцоо болон бусад эрхийн актаар зохицуулна.

5.5. Гэрээний талууд шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөл: Ашиглалтын газраа гэрээнд заасны дагуу зориулалтаар нь эзэмшиж ашиглана. Мөн гэрээг талууд жил бүр дүгнэнэ.

ЗҮРГАА. Бусад зүйл

6.1 Гэрээ нь газар ашиглагчид газрыг актаар хүлээлгэн өгч, эрх бүхий Засаг дарга газар ашиглах эрхийн гэрчилгээ олгосон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж мөрдөгднө.

6.2 Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэж талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн Таван /үсгээр/ жилийн хугацаатай байгуулав.

6.3 Энэхүү гэрээтэй холбоотой бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Гэрээний талуудын албан ёсны хаяг, харилцах утас:

Говь-Алтай аймаг, Цээл сумын ЗДТГ-ын

Газар ашиглуулагч: Газрын харилцаа хариуцсан мэргэжилтэн Б.Насанбуян

Утас: 99062636

Газар ашиглагч: "Алтайн Хүдэр" ХХК

Таян нуур уурхай

Регистр /улсын бүртгэл/-ийн дугаар 5095549

Харилцах дансны дугаар _____

Харилцах утас _____

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Газар ашиглуулагчийг төлөөлж:

Говь-Алтай Аймаг/нийслэл/-ийн
Цээл сум -ийн Газрын
асуудал эрхэлсэн албан тушаалтан
Баасанжавс овогтой Насанбуян

ГАРЫН
АШИГЛУУЛГАТ
ХОЛОХ
/гарын үсэг/ /тамга/

Газар ашиглагчийг төлөөлж:

"Алтайн Хүдэр" ХХК-ын
Одигтуулын чурагийн
хүүс Зүйн сэргээлийн дэргэ
Д. Батмурэнжийн

ГАРЫН
АШИГЛУУЛГАТ
ХОЛОХ
/гарын үсэг/ /тамга/
ITA4086 5095549

Энэхүү гэрээний нэг хувийг 8212000387 тоот дугаар бүхий нэгж талбарын хувийн хэрэгт хадгалав.